



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 323

Улаанбаатар хот


“Аэрогеодези” ХК-ийн үнэт цаасыг
үнэт цаасны бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах тухай журам”-ын 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Аэрогеодези” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 3,806,767 ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, Хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦГТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Энэ тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргэн, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001016